



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Монгол Улсын Их Сургууль
Шинжлэх Ухааны Сургууль,
Байгалийн Ухааны салбар

Хөтөлбөрийн нэр: Биохими

Индекс: D 051201

Шинжээчийн баг:

Ахлагч: А.Гүрбадам

Гишүүд: З.Бурмаа

Н.Эрдэнэчимэг

2022 он

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

БШУЯ Боловсрол, шинжлэх ухааны яам

БМИҮЗ Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний зөвлөл

ГХССТ Гадаад хэл, соёл судлалын тэнхим

МУИС Монгол улсын их сургууль

ШУС Шинжлэх ухааны сургууль

БУС Байгалийн ухааны сургууль

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

| | | |
|--|--|--|
| Сургуулийн нэр /Монгол, Англи/ | Монгол Улсын их сургууль National University of Mongolia | |
| Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/ | Биохими Biochemistry | |
| Индекс | D 051201 | |
| Шинжээчид | <ol style="list-style-type: none"> 1. А.Гүрбадам /Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Био-анагаах сургуулийн профессор, доктор/ 2. Н.Эрдэнэчимэг /ШУА-ийн хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор/ 3. З.Бурмаа /Ховд Их сургуулийн Байгалийн шинжлэл, технологийн сургуулийн багш, дэд проф. доктор/ | |
| БМИҮЗ-ийн Мэргэжилтэн | Г. Даваажаргал /БМИҮЗ-ийн ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн/ | |
| Төлөвлөгөө | Он сар өдөр | Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/ |
| | 2022-03-09 | Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн Ажлын албаны захирал О.Янжмаа үг хэлж, шинжээчийн багийг хүлээлгэн өгнө. Шинжээчийн багийн ахлагч магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулна. Сургуулийн захирал үг хэлнэ . Хөтөлбөрийн товч танилцуулга /тайлан бичсэнээс хойших мэдээллийг оруулах/ |
| | | Сургуулийн орчинтой танилцах |
| | | Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах |
| | | Багш нартай уулзах |

| | | |
|----------------------------------|--|---|
| | | Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах |
| | | Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг |
| | 2022-03-10 | Шинжээчийн багийн уулзалт |
| | | Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах |
| | | Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах |
| | | Оюутнуудтай уулзах |
| | | Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах |
| | | Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг |
| | | Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ. |
| Шалгуур шаардлага /журам/ | БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур | |

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУИС-д Биохимич мэргэжилтэн бэлтгэн эхэлснээс хойш даруй 53 жилийг үдээд байна. 1942.10.05-нд МУИС анхны хичээлийн шинэ жилийн нээлтээ хийж Зоотехник - мал эмнэлгийн, Анагаах ухааны, Багш нарын факультеттэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба Багш нарын факультет 7 тэнхимтэй байсанд Химийн болон Биологийн тэнхим (1942-1951) багтаж байсан.

1951 оноос МУИС-д Хими-Биологийн салбар байгуулагдсан. Ингэснээр Химийн тэнхим нь Ерөнхий химийн тэнхим, Органик ба Биохимийн тэнхим болж салбарласан үеэс эхлэн биохимич мэргэжилтэн бэлтгэх суурь тавигдсан. МУИС-д 1966 оноос биохимич мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн бөгөөд анхны 9 биохимичийг 1968 онд төгсгөжээ. Энэ хугацаанд 55 төгсөлтөөр 395 гаруй биохимичид суралцан төгсөж эх орныхоо өнцөг булан бүрд боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага, улсын болон хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн байгууллага, судалгаа, шинжилгээний лабораториудад үр бүтээлтэй ажиллаж байна. Эдүгээ МУИС дээр Биохими мэргэжлээр төгсөлтийн өмнөх бакалаврын болон төгсөлтийн дараах магистр, докторын гурван шатны сургалт хэрэгжиж байна.

Мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн батлах тухай БШУ-ы сайдын А/78 тоот тушаал 2014 оны 03 сарын 13-нд гарсан бөгөөд тушаалын хавсралтаар дээд боловсролын байгууллагад бэлтгэх бакалаврын сургалтын мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн баталсан. Уг тушаалаар “Биохими”-ийн чиглэлээр бие даан мэргэжилтэн бэлтгэх чиглэл батлагдсан. Энэ нь улам өргөжин тэлж буй шинжлэх ухааны энэхүү чиглэлээр биологи болон химийн гүнзгий суурь мэдлэгтэй биохимич нарыг бэлтгэх бололцоог олгосон. Биохимийн бакалаврын хөтөлбөр нь хөдөлмөрийн зах зээл дээр хөрвөх чадвартай биологи

болон химийн шинжлэх ухааны онол, дадлагын өндөр түвшний мэдлэгтэй, гүйцэтгэгчээс анхан шатны удирдлагын түвшинд; хүнс, эмийн үйлдвэрлэлийн; мэргэжлийн хяналт, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагуудад судалгаа шинжилгээний ажил хийх чадвартай; анагаах ухаан, хөдөө аж ахуй, хүнсний салбарт технологи боловсруулах; их, дээд сургуульд багшлах чадвартай боловсон хүчин бэлтгэн гаргахад чиглэгдэж байна. Биохимийн мэргэжилтэн бэлтгэх сургалт, судалгааны орчныг сайжруулах зорилгоор Биохимийн лабораторид Засгийн газраас 90 сая төгрөгийн, 2014-2015 хичээлийн жилд Азийн хөгжлийн банкнаас 153 сая төгрөгийн, багш нарын хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдээс 824.129.738 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж материаллаг баазаа бэхжүүлсэн нь сургалт судалгааны орчин нөхцөлийг сайжруулахад томоохон дэмжлэг болсон.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Биохими хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний шинэчлэлүүдтэй танилцаж, батлагдсан төлөвлөгөөнүүдийг харьцуулан харав.
- Биологийн тэнхимд хэрэгжиж буй ижил төстэй хөтөлбөрүүдийн сургалтын төлөвлөгөөнүүдийг хавсаргасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Биологийн тэнхимийн бусад хөтөлбөрт суралцагчдад Биохими бакалаврын хөтөлбөрөөр суралцах боломж нээлттэй, бусад хөтөлбөрөөс багц цагийн зөрүү бага байна.
- Тухайн мэргэжлээр Монгол Улсад хэрэгжиж буй ганц хөтөлбөр

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөтэй багш бүр сайн танилцсан, нэгдсэн ойлголттой байх, өөрчлөлт шинэчлэлтийн талаар санал бодлоо тогтмол илэрхийлэх, шат шатанд нь шийдвэрлүүлэхэд анхаарах, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулахад идэвх санаачилгатай оролцох

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн лекцийг бага, дадлага, семинар, лабораторийн цагийг ахиу орох, зохимжтой харьцаагаар оруулах

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Биохими сургалтын хөтөлбөрийн мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийн батлагдсан хөтөлбөрүүдтэй танилцав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Биохими хөтөлбөр нь биологийн шинжлэх ухааны (Амьтан, Ургамал, Бичил биетэн, Биофизик, Генетик, Экологи) болон технологи (Хүнс, Эм зүй, Оношилгоо, ХАА) интеграцчилсан, шинжлэх ухааны олон салбарыг багтааснаараа онцлог.
- Уг хөтөлбөр нь суралцагчдад өргөн хүрээний мэдлэгийг олгох, нөгөө талаас атом молекулын түвшинд технологийн мэдлэгийг эзэмшүүлэх зорилготой. Иймээс уг хөтөлбөрийн онцлог нь суралцагчдад (систем биологи+технологи) боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд чиглэгдсэн хөтөлбөр байна.
- Биохими хөтөлбөрт суралцсанаар төгсөгч улс орны өмнө тавигдаж буй онолын асуудлаас хэрэглээний түвшин хүртэлх асуудлыг боловсруулж шийдвэрлэх чадвартай боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх хөтөлбөр байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын явцад хөтөлбөрт суралцагч болон ажил олгогч талуудын санал зөвлөмжийг тусган хичээлүүдийн хэлбэр, агуулга, арга зүйг тогтмол өөрчлөн сайжруулахад анхаарах

Зөвлөмж:

- Ажил олгогчдын саналын үндсэн дээр тухайн салбарт мэргэшсэн /анагаах, мал эмнэлэг, ХАА, ШУА-ийн хүрээлэнгүүд/ биохимичдийг бэлтгэх.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөөнд буй хичээлүүдийн сургалтын хөтөлбөрийг хавсаргасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Биохими бакалаврын сургалтыг 1966 оноос хэрэгжүүлж, хөтөлбөрийн хамт олон 55 жилийн туршлагатай өндөр мэргэшсэн (75% докторын зэрэгтэй) боловсон хүчин төвлөрүүлсэн баг хамт олон.
- Монгол улсад биохимич мэргэжилтэн шаталсан системээр бэлтгэдэг цорын ганц биохимийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Биохимийн үндсэн сурах бичгүүдийг туурвисан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр боловсруулах үйл явцад оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, төлөөллийг оролцуулах ажлыг сайжруулах хөтөлбөрийн тогтсон үнэлгээний системтэй болох.
- Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг тогтмол хийж, хөтөлбөрийн хөрвөх чадварт тулгуурлан сургалтын төлөвлөгөөг тогтмол шинэчилж байх

Зөвлөмж:

- Биохими хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний шинэчлэлийг хийх
- Гадаад оюутан сургах бодлого боловсруулж хэрэгжүүлэх
- Гадаадын ижил мэргэжлийн их дээд сургуулиудтай бакалаврын оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч болон сонирхогч талуудыг хамруулан тэдгээрийн хэрэгцээ, сонирхолыг судлан тогтмол дүн шинжилгээ хийж, хөтөлбөрөө сайжруулж байх

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн цахим сургалтын журам
- Биологийн тэнхимийн бусад хөтөлбөр хоорондын интеграцийг хүснэгтлэн харьцуулсан.
- МУИС-ийн бакалаврын сургалтын журам
-

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Биохими хөтөлбөрийн агуулга багц цагийн хүрээнд Ерөнхий суурийн хичээл 45 багц цаг, Үндсэн мэргэжлийн 45 багц цаг, Мэргэшүүлэх хичээл 15 багц цаг, Чөлөөт сонголтын хичээл 15 багц цаг, нийт 120 багц цаг судлах ба мэргэжлийн суурь хичээлийн нийт агуулгын 55,6% нь лекцээр, 13,3% нь семинар, 31,1% нь лабораторийн хичээлүүдээр олгож байна.
- Мэргэжлийн сонгон судлах хичээлийн нийт агуулгын 66.7% нь лекц, 33,3% нь семинарын хичээлүүдээр тус тус олгож байна. Оюутан хүрч ажиллахад семинар, лабораторийн хичээлийн харьцаа хангалттай сайн байна.
- МУИС-ийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлээс сонгон суралцахаар төлөвлөсөн суралцагчдад цаг хугацаа, орон зайнаас үл хамааруулан боловсролын үйлчилгээг хүргэх боломжийг бий болгосон цахим сургалтын арга хэрэгслийг МУИС ашигладаг.
- Биологийн тэнхимийн 6 хөтөлбөрийн багц цагийн давхцал мэргэжлийн заавал судлах хичээлийн хувьд 26 кр байна. Мэргэжлийн суурь хичээлийн багц цагийн (45 кр) давхцал 57,78%-тай байгаа нь бакалаврын хоёр дахь хөтөлбөрөөр суралцах боломжийг оюутнуудад олгож байна.

Анхаарах асуудал:

- Цаашид сургалтын төлөвлөгөөгөө шинэчлэхдээ хичээлүүдийн онол, дадлагын харьцаа 2:1 байгааг анхаарах;
- Сургалтын төлөвлөгөөнд багтсан хичээлүүд нь бусад их дээд сургуулийн ижил төстэй хөтөлбөрөөс шилжин ирж суралцах эсвэл энэ хөтөлбөрөөс бусад хөтөлбөр лүү шилжиж суралцах боломжийг суралцагчдад бий болгох дээр анхаарах /дүйцүүлэх болон ижил төст хичээлүүдийг сайтар тусган оруулсан байх/;

Зөвлөмж:

- Хичээлийн хөтөлбөрийн агуулгад оролцогч, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ, санал хүсэлтийг тодорхой хэмжээгээр тусган тогтмол шинэчилж байх;
- Биохимийн хөтөлбөрөөр төгсөж буй дипломын ажил бичээгүй оюутнуудаас улсын шалгалт авах, эсвэл бүгд диплом бичдэг болгох асуудалд анхаарах;

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын лабораториудын шинэчлэл, оюутанд хүртээмжтэй байдал
- Хичээл заадаг багш нарын хичээлийн хөтөлбөрүүдийн багц материалуудтай танилцав.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын арга зүйн шинэчлэлийг хийхдээ материаллаг баазаа сайжруулах дээр анхаарсан байна.
- Багш нар нөхцөл байдалтай уялдан 20 гаруй төрлийн платформ, программ, веб сайт, бусад системийг ашиглаж сургалтыг зохион байгуулж байна.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар Биохими хөтөлбөрийн хичээлүүдийн багш, сургалтын орчин, хичээлийн талаар 88%-аас дээш үзүүлэлттэй байна.

Анхаарах асуудал:

- Оюутнуудад танхимын сургалтаас гадна онлайн хичээлд суралцах программ хангамжуудын мэдлэгийг олгоход анхаарах;

Зөвлөмж:

- Биохими хөтөлбөрөөр төгсөгчдөд хичээл зааж буй мэргэжлийн залуу боловсон хүчний боловсрол судлал, сурган заах арга зүйн сургалтад тогтмол хамруулах, давтан сургахад анхаарах;

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн бакалаврын сургалтын журам
- МУИС-д хичээл дүйцүүлэх журам /2021 оны А/361 тоот тушаалаар/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС нь бусад сургуулийн багц цагийг тооцох, суралцагч голч дүнгээ хянах, дүнгээ ахиулах боломж олгох үүднээс үндсэн үнэлгээг хэрэглэхээс гадна нэмэлт тэмдэглэгээг хэрэглэдэг.
- Биохими хөтөлбөрийн оюутнуудын мэдлэг, чадвар, хандлагыг харьцангуй бодитой дүгнэж байна.
- Хөтөлбөрийн багш нар олон улсын болон дотоодын эх үүсвэр бүхий төслүүдийг хэрэгжүүлж, сургалт, судалгааны лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулахаас гадна оюутан, суралцагчдыг судалгааны ажилд татан оруулж, ажлын байранд зуучлах, ахисан түвшинд суралцах боломжуудыг бий болгож байна.

Анхаарах асуудал:

- Оюутнуудад бакалаврын сургалтын журмыг сайтар танилцуулах дээр анхаарах;
- Оюутнуудын техник технологийн боломж хурдад тохируулан цахим сургалтын дадалд харьцангуй хөнгөн, үйлдлийн систем болон өндөр үзүүлэлт шаардахгүй технологи нэвтрүүлэх дээр анхаарах /Зарим хичээлийг зайнаас суралцах боломжийг тогтмол бий болгох/;

Зөвлөмж:

- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйгээ тасралтгүй сайжруулах.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

МУИС-ийн Биохими хөтөлбөрийн сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, багшийн ажиллах орчин стандартын шаардлага хангасан, тохижилт хийгдсэн, оюутнуудыг багаар болон бие даан ажиллах нөхцөлөөр хангасан.

Илрэл нотолгоо:

- Сургалтын анги танхим, лабораторид 2015-2017 онуудад их засвар засвар хийж тохижуулсан.
- Лекцийн 4, семинарын 7, лабораторийн 11, судалгааны 4 лабораторитай. Нэг оюутанд 1.17 м² талбай ноогдож байна.
- Лабораториуд сургалт, судалгаанд шаардлагатай багаж төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд лаборатори бүрд галын хор, анхан шатны тусламжийн хайрцаг аюулгүй ажиллагааны зааварчилгаа байрлуулсан.
- Оюутнууд профессорын багийн төсөлд хамрагдах боломжтой.
- Хичээлийн байрны давхар бүрд оюутан сууж ажиллах ширээ сандал, халуун хүйтэн усны шүүлтүүр байрлуулсан.
- Хичээлийн болон оюутны байр утасгүй сүлжээнд бүрэн холбогдсон.
- Оюутны бие даалтын төвтэй.
- Багш, ажилчдын ажиллах орчныг стандартын дагуу бүрдүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын орчин, нэг оюутанд ноогдох лаборатори, тоног төхөөрөмж, бодис урвалж лабораторийн орчны сайжруулалт тасралтгүй хийгдсээр байна.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын бие даан суралцах анги, танхимын тоог нэмэгдүүлэх;
- Сургуулийн орчны интернэтийн хурдыг нэмэгдүүлэх, ялангуяа, хичээл сонголтын үеэр;

Зөвлөмж:

- Суралцагчдын үдийн цай уух, чөлөөт цагаараа ярилцах орчныг бий болгох

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Сургалтын лабораториуд сургалтад ашиглах орчин үеийн багаж төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Сургалтын заавар, удирдамж болон сургалтад шаардлагатай урвалж, шил сав хангалттай, жил бүр худалдан авалт хийдэг.

Илрэл нотолгоо:

- Сүүлийн 5 жилд (2015-2020 онуудад) Биохими, биотехнологи, Микробиологи, Биофизик, Генетик-молекул биологийн лабораторид 77.8 сая төгрөгийн өртөг бүхий 30 орчим тоног төхөөрөмж, 101.9 сая төгрөгийн өртөг бүхий шил сав, урвалж бодис худалдан авч сургалтад ашиглаж байна (өөрийн үнэлгээний тайлан х.41, ӨҮТ-ийн хавсралт 3.1.4)
- Биохими лабораторийн 18 хичээлийг видео хэлбэрт оруулсан (124 мин, SiSi систем, Microsoft Teams платформ)
- Оюутны лабораторийн хичээлд тэнхимийн “Микроорганизмын өсгөврийн сан”-д хадгалагдаж байгаа дрожжийн 110 өсгөвөр, термофилийн 29 өсгөвөр, *E.coli*, *S.aureus*, *Ps.auroginasa*, *E.faecalis*, *M.luteus* гэсэн 5 тест штамм ашиглах боломжтой (Хавсралт 3.2.1).
- Лабораторийн бүх хичээлд дадлага ажлын дэвтэр ашигладаг.
- Хөтөлбөрийн багш нар лабораторийн хичээлийн заавар 96, үйлдвэрлэлийн дадлагын удирдамж 3-ыг боловсруулан ашиглаж байна.
- Сургалт, судалгаанд ашиглах CD Z

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Лабораторийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалалд ихээхэн анхаарал хандуулж ажилладаг.
- Химийн бодисын хаягдлыг устгах хамтын ажиллагааны гэрээг “Түмэн эгшиг” ХХК-тай байгуулсан.

Анхаарах асуудал:

- Е-контент болон видео хичээлийн тоог нэмэгдүүлэх;
- Бодис урвалж хадгалах стандарт шаардлагыг хангасан өрөө, тасалгааны хүрэлцээ Дутмаг;

Зөвлөмж:

- Бодис урвалж хадгалах стандарт шаардлагыг хангасан өрөө, тасалгаатай болох;

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

МУИС болон Биологийн тэнхим хэрэгцээт ном, сурах бичгийн фондын бүрдүүлэлтийг жил бүр системтэйгээр хийдэг, зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлээр цахим сан хөмрөгийн баяжилт байнга хийгддэг, дижитал номын сан мэдээллийн сан ашигладаг.

Илрэл нотолгоо:

- МУИС стандартын шаардлага хангасан жишиг номын сантай. EBSCO HOST, Royal society, Annual reviews, PNAS, JSTOR, SPIE Digital Library, Ecological society of America, Springer, Sage publisher зэрэг 16 мэдээллийн санг ашиглах боломж бүрдүүлсэн.
- Номын сангийн уншлагын танхим бүр оюутнуудын багаар ажиллах өрөөтэй.
- Номын сангийн фондод Биохими хөтөлбөрт хэрэглэгддэг 4400 орчим ном, үндсэн сурах бичиг (Монгол, Англи, Орос, Герман хэл дээр) байна.
- Хөтөлбөрийн багш нар сурах бичиг гаргах, орчуулах, сургалтын гарын авлага боловсруулах замаар мэдээллийн эх үүсвэрийг байнга бүрдүүлдэг.
- Сүүлийн 3 жилд тус хөтөлбөр 144 ном, сурах бичгээр баяжуулалт хийсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Номын сангийн зүгээс оюутнуудын саналд үндэслэн эрэлт ихтэй зарим ном, сурах бичгийн зохиогчидтой холбогдон дахин хэвлүүлэх хүсэлт гарган мэргэжлийн ном сурах бичгийн баяжуулалт хийдэг.
- Хөтөлбөрийн багш нар өөрсдийн заадаг хичээл болон судалгааны ажлын чиглэлийн англи хэл дээрх хичээлийн ном сурах бичгийг цахим хэлбэрээр хадгалж, сургалтад ашигладаг.
- МУИС-ийн номын сан КОХА систем нэвтрүүлснээр багш оюутнууд өөрийн кодыг ашиглан хаанаас ч цахим номын сан ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн үндсэн ном, сурах бичиг сэтгүүлийн хүртээмжийг сайжруулах;
- Монгол хэл дээрх сурах бичгийн тоог нэмэгдүүлэх;

Зөвлөмж:

- Зарим хичээлийн сурах бичгийг сүүлийн үеийн нэмэлт өөрчлөлт оруулж дахин хэвлэсэн сурах бичгээр баяжуулах;
- Шаардлагатай сурах бичгийг эрх авч эх хэлнээ орчуулах;
- Дижитал номын сангийн ашиглалтыг сайжруулах;

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Дэлхийн шилдэг их дээд сургуулийн хөтөлбөрийн агуулгыг харьцуулан судалсны үндсэн дээр тэнхимийн багш нар “Биохими” сургалтын хөтөлбөрийг боловсруулж тэнхим, ШУС-ийн хөтөлбөрийн дэд хороо болон хөтөлбөрийн ерөнхий хороогоор хэлэлцүүлж батлуулдаг.
- 2019 онд хөтөлбөрт өөрчлөлт хийж Биозохицуулагчид хичээлийн кредит цагийг нэмэгдүүлж, хичээл хоорондын залгамж холбоог хангах зорилгоор хичээлийн орох улирлыг өөрчилсөн, үүнийг дагаад хичээлийн индекс өөрчлөгдсөн; мөн ургамлын биохими хичээлийн орох улирлыг өөрчилсөн, үүнийг дагаад хичээлийн индекс өөрчлөгдсөн.
- Техникийн биохими хичээлийг сонгон бүлэгт оруулсан.
- Бакалаврын судалгааны ажил хичээлийг сонгох урьдчилсан нөхцөл болох 6 улирлын сурлагын голч 80 онооны босгыг хассанаар оюутнуудад уг хичээлийг сонгон суралцах боломж нээгдсэн зэрэг өөрчлөлт хийсэн байна (Хөтөлбөрийн хорооны хурлын протокол, ӨҮТ, х.131).
- Оюутны хичээлийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн хичээлийн арга зүй, агуулгад микро түвшний өөрчлөлт оруулдаг (ӨҮТ, х.68-70).
- Оюутнуудаас хөтөлбөртэй холбоотой (хичээл дүйцүүлэх, үйлдвэрлэлийн дадлагыг нөхөж хийх, хичээл хуваарьт оруулах гм) санал гомдлыг хүлээн авч тухай бүр шийдвэрлэсэн.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь МУИС-ийн 2016-2024 он хүртэлх хөгжлийн шинэчилсэн стратеги төлөвлөгөө болон тухайн жилийн төлөвлөгөөг мөрдлөг болгон ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн удирдлага, сургалтын алба, багш, оюутнууд мэдээллийн SiSi системийг сургалтын бүхий л үйл ажиллагаанд ашигладаг, үйл ажиллагаа нь тогтмолжсон, сургалтын үйл ажиллагаатай холбоотой ихэнх журмын хэрэгжилтэд хяналт тавих боломж бүрдүүлсэн.
- МУИС Хичээлийн сэтгэл ханамжийн судалгааг оюутнуудаас улирал бүр авдаг SiSi системээр дамжуулан авч хөтөлбөрийн хэрэгжилт болон шинэчлэлтийн үр нөлөөг үнэлэхэд ашигладаг байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн хөтөлбөрийн агуулгад оролцогч, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ, санал хүсэлтийг тодорхой хэмжээгээр тусган тогтмол шинэчилж байх;

Зөвлөмж:

- Оюутнуудын англи хэлний чадварыг сайжруулах арга зам олох, сургалт зохион байгуулах, хөтөлбөрт тусгах гм

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Олон улсын болон дотоодын хамтарсан төсөл хэрэгжүүлэх, олон улсын болон оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, нийгэмд үзүүлэх олон талт үйлчилгээ тогтмолжсон байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн багш нар гадаад, дотоодын хамтарсан төсөлт хөтөлбөр хэрэгжүүлдэг нь бакалавр, магистр, докторын түвшний оюутнуудад олон чиглэлд судалгаа хийх материаллаг бааз суурийг бүрдүүлсэн.
- Оюутнуудын дунд эрдэм шинжилгээний бага хурал тогтмол зохион байгуулдаг;
- 2019 онд Сүү ХХК-тай биохимич, биотехнологич мэргэжлийн үйлдвэрлэлийн дадлагын хичээлийн гэрээг 3 жилийн хугацаатай байгуулсан.
- 2016-2020 оны хооронд нийт 44 оюутан үйлдвэрлэлийн дадлагаа шинжлэх ухааны хүрээлэн, үйлдвэр аж ахуйн нэгжийн 6 байгууллагад хийсэн.
- 2015-2020 онуудад 6 оюутан (МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг – 4 оюутан, Зориг сан ба Мерали сангийн нэрэмжит тэтгэлэг - 1, Намянжү сангийн нэрэмжит - 1, ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг -1) нийт 7 тэтгэлэг хүртсэн.
- Сакура Сайнс хөтөлбөрийн хүрээнд 10 оюутан Японы Осака Их Сургуульд богино хугацааны сургалтад хамрагдсан.
- Тэнхимийн багш нар ААН, байгууллагын захиалгаар гэрээт, захиалгат ажил гүйцэтгэхээс гадна мэргэжил арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төсөл захиалгат ажил, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд багш нарын оролцоо жигд (ӨҮТ, х. 67).

Анхаарах асуудал:

- Төгсөгчидтэй эргэх холбоотой ажиллах, давтан сургалт явуулах, мэргэшүүлэх;
- Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

Зөвлөмж:

- Гадаадын ижил мэргэжлийн их дээд сургуулиудтай бакалаврын оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Ажил олгогчдын саналын үндсэн дээр тухайн салбарт мэргэшсэн (анагаах ухаан, ХАА, мал эмнэлэг, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд) биохимичдийг бэлтгэх;

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн жилийн төсвийн 76 - 78%-ийг оюутны төлбөр бүрдүүлдэг. Биологийн тэнхим 2018, 2019 онуудад 1.8 - 2.3 тэрбум төгрөгийн төсвийн зарцуулсан. (МУИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилийн тайлан). Сүүлийн 5 жилд Тэнхимийн харьяа хөтөлбөрүүдийн үр дүнг нэмэгдүүлэх, ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн орчныг сайжруулах зорилгоор тэнхимийн лаборатори, анги танхимыг засах, тохижуулах, шинээр сургалтын лаборатори тохижуулах, багаж тоног төхөөрөмж худалдан авахад зориулж МУИС-ийн төвлөрсөн сан, ШУС-ийн төсөв, бусад эх үүсвэрүүдээс нийт 179.7 сая ₮ зарцуулсан байна.
- Хөтөлбөрийн багш нар МУИС, ШУТС санхүүжилтээр 474,4 сая ₮ өртөг бүхий 19 төсөл, олон улсын хамтарсан 10 төслийн хэрэгжүүлсэн.
- МУИС дээр хэрэгжүүлж буй төслийн санхүүжилтээс шимтгэл төлдөг бөгөөд энэ нь эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх орлогын эх үүсвэрийн тодорхой хувийг бүрдүүлдэг. (Судалгааны санхүүжилтээс МУИС-д шууд бус зардлын хуримтлал бүрдүүлэхэд баримтлах журам, МУИС-ийн захирлын 2016 оны 06 сарын 28-ны өдрийн А/162 тоот тушаал)
- Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш оюутны хөгжилд зарцуулагддаг (12 сая ₮ санхүүжилт болон оюутны тэтгэлэг, ном сурах бичиг худалдан авах гм).
- Тэнхимийн багш нар 2017-2020 онд 27-36 сая ₮ дэмжлэг авч судалгааны ажилд зарцуулсан.
- Хөтөлбөрийн багш нар профессорын суурь судалгаа болон гадаад дотоодын хамтарсан төсөл хөтөлбөрийн хүрээнд 2017-2018 оны хичээлийн жилд 29 оюутанд 32,9 сая төгрөг, 2018-2019 онд 47 оюутанд 85.6 сая төгрөг, 2019-2020 онд 35 оюутанд 101.9 сая төгрөгийн тэтгэлэг олгосон байна.
- 2014 онд 10-15 оюутан суух багтаамжтай бие даалтын төвийг хандиваар байгуулсан.
- 8500 гаруй ном хэвлэлийн бүтээгдэхүүний биет хандив авсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийг дэмжих зорилгын хүрээнд тэнхимд жил бүр 12 сая төгрөгийн төсөв олгодог (эмчийн үзлэг, туршлага солилцох, сургалт, ном сурах бичиг худалдах авах, хурал семинар зохион байгуулахад зарцуулсан).
- Профессор багшид 2 сая, дэд профессор болон 5 хүртэл жилийн өмнө докторын зэрэг хамгаалсан ахлах багшид судалгааны лабораторийн удирдагч эсэхээс

хамааран 1-3 сая төгрөгийн суурь судалгааны зардал олгодог (МУИС-ийн захирлын 2018 оны 11 сарын 27-ны өдрийн А/52 тоот тушаал).

- Хөтөлбөрийн багш нар МУИС, ШУТС санхүүжилтээр 474,4 сая ₮ өртөг бүхий 19 төсөл хэрэгжүүлсэн.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлэхийн тулд санхүүгийн олон эх үүсвэртэй болох;
- Нэг оюутанд ноогдох өртөг зардлын тооцоог гаргах;

Зөвлөмж:

- Гадаад оюутан сургах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Төслийн үр дүнг практикт нэвтрүүлэх, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах;

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг 3 жилд 1 удаа авч хөтөлбөрийн идэвхжүүлэлт хийдэг.
- Жил бүр 2-3 удаа ЕБС-ийн багш нар, мэргэжлээ сонгох гэж буй оюутнуудад Биологийн тэнхимийн хөтөлбөрүүд, Биохимийн хөтөлбөрийн сургалтын орчин, үйл ажиллагаа, мэргэжлийн давуу тал, хэрэгцээт байдал, төгсөгчдийн ажил эрхлэлтийн талаарх тодорхой мэдээллийг өгч хөтөлбөр таниулах өдөрлөг зохион байгуулдаг.
- Сурталчилгааны мэдээллийг Сургалтын нэгдсэн албанаас хэвлэмэл материал, видео танилцуулга байдлаар бэлтгэж БШУЯ, Аймаг орон нутгийн удирдлагууд, ТББ зэргээр дамжуулан хүргэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- I, II түвшний ерөнхий суурь хичээлийн багш нараар дамжуулан хөтөлбөрөө сурталчилдаг.
- Сурталчилгааны үеэр Биохими биотехнологийн мэргэжлийн онцлогийг харуулсан хялбар туршилт явуулах болон энэ мэргэжлийг сонгосноор ирээдүйд ямар чадвартай боловсон хүчин болох, хаана ямар байгууллагуудад ажиллаж болох, цаашид ямар боломж, бололцоо байгаа зэрэг танилцуулга хийгддэг.
- 2019 онд JOB Fair буюу ажлын байрны өдөрлөг зохион байгуулсан.

Анхаарах асуудал:

- Бакалаврын зарим хичээлийг англи хэл дээр судлах боломжийг бий болгох;
-

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийг нэмэгдүүлэх, ЕБС-ийн дунд ангиас эхлэн биохимийн шинжлэх ухааны ач холбогдол, хэрэглээг таниулан сурталчлах;
- Мэргэжилтний зах зээлийн судалгаа, прогноз гаргах, төлөвлөх, хөтөлбөрт элсүүлэх оюутны тоог нэмэгдүүлэх, сургалтын төлбөрийн үнэлгээг нэмэгдүүлж, улмаар сургалтын чанарт өөрчлөлт дэвшил гаргах;

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-д хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн танилцуулга, суралцахуйн зорилтот үр дүн, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөөний бүтэц, суралцах ачаалал, багц цаг, суралцахуйн үнэлгээний аргачлал зэрэг хөтөлбөртэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэйгээр дараах албан ёсны эх сурвалжуудаар түгээдэг. Үүнд:

<https://www.num.edu.mn/> - МУИС-ийн цахим хуудас

<https://elselt.num.edu.mn/> - МУИС-ийн Элсэлтийн цахим хуудас

<https://burtgel.num.edu.mn/negdsen> - МУИС-ийн Бүртгэлийн нэгдсэн систем

<https://graduate.num.edu.mn/> - Ахисан түвшний сургуулийн цахим хуудас

<https://sas.num.edu.mn/>

<http://dep.num.edu.mn/biology/>

Фейсбүүк-БИОТА (МУИС-ийн Биологи Төгсөгчдийн Холбоо)

<https://www.facebook.com/groups/301799026675274>

Фейсбүүк- Биологийн тэнхим МУИС-ШУС-БУС

<https://www.facebook.com/profile.php?id=100010193958414>

Фейсбүүк- МУИС, ББС-ийн Биохими, Биоорганик химийн тэнхимийн төгсөгчид

<https://www.facebook.com/groups/430097970414395>

Фейсбүүк- МУИС-Биохими төгсөгчид

<https://www.facebook.com/groups/255059075211877>

- МУИС-ийн сургалтын удирдлага, мэдээллийн SISI систем <https://sisi.num.edu.mn>– ээр дэлгэрэнгүй мэдээллийг хүргэж, тогтмол шинэчилж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр нь МУИС-аас хэрэгжүүлж буй төлөвлөгөөнд хамрагдан хөтөлбөрийн талаарх мэдээллийг албан ёсны цахим хуудсаар нийтэд нээлттэй, ил тод мэдээлдэг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөртэй холбоотой мэдээлэл (давуу тал, мэргэжилтний зах зээлийн эрэлт хэрэгцээ болон ажлын байр гм) бүхий гарын авлага, таниулах материалыг бэлтгэж мэдээлж байх

Зөвлөмж:

- Сургалтын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхэл анхаарч ажиллах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-д оюутан элсүүлэх журам
- Сургалтын бодлогын хүрээнд дараах боломжуудыг суралцагчид олгодог. Үүнд:
- Элссэн оюутан үндсэн мэргэжлээс гадна МУИС-аас санал болгох “Хос” болон “Хавсарга” мэргэжлээс сонгон судлах;
- ШУС болон ХШУИС-д элсэгчид гүнзгийрүүлсэн сургалттай хөтөлбөр (honours program)- т хамрагдах;
- МУИС-ийн ерөнхий суурийн зарим хичээлийг англи хэл дээр сонгон судлах;
- Сургалтын журмын 4.6.11.8 заалтын дагуу Монгол Улсад Кембриджийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй “Орчлон” олон улсын дунд сургууль, БШУЯ-ны харьяа олон улсын хөтөлбөрийн сургалттай “Шинэ эхлэл”, “Шинэ эрин”, “Монгол тэмүүлэл” лаборатори сургуулиудыг төгсөж МУИС-д элссэн оюутнуудын А болон AS түвшинд судалсан хичээлийг МУИС-ийн Ерөнхий суурийн хичээлтэй багц цаг дүйцүүлэн тооцдог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

• МУИС, ШУС, БУС-ийн Биологийн тэнхим, Биохимийн хөтөлбөрт элсэгчдийн тоог сүүлийн 5 жилийн дунджаас харахад 18-19 оюутан элсэн суралцаж байна. Үүнийг тухайн жилд БШУЯ-наас олгосон квот/тоо-ын тоотой харьцуулахад 90.47%-ийн биелэлттэй буюу жилд элсүүлэх элсэгчдийн тоог бүрэн биелүүлсэн байна.

- Биохими хөтөлбөр тасралтгүй хэрэгжиж байна..

Анхаарах асуудал:

• Биохими хөтөлбөрөөр элсэгчдийг биологийн хичээлээс гадна математик, физик, химийн хичээл суурьтай элсэгчдийг элсүүлэх тал дээр анхаарах;

- Тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдах оюутны тоог нэмэгдүүлэх замаар элсэгчдийг татах;
- Хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар элсэлтийн бодлогоо сайжруула
- Богино хугацааны оюутан солилцооны хөтөлбөрийг гадаад, дотоодын их, дээд сургуулиудтай хэрэгжүүлэх дээр анхаарах. Энэ нь элсэгчдийг татах чухал арга зам болно.

Зөвлөмж:

- Биохими хөтөлбөрөөр элсэгчдийн элсэлтийн шалгалтыг биологи, хими, математик, физикийн хичээл болгох нь элсэн орж буй суралцагчдын суурь мэдлэг дээр тулгуурлан биохими хөтөлбөрөөр суралцагчдад бакалаврын сургалтаар мэдлэг эзэмшихэд нь илүү ойр, үр дүнг гарах боломж илүү байна.
- Биологийн тэнхимийн бусад хөтөлбөрийн талаар суралцагч нарт нээлттэй мэдээлэл өгөх, мэргэжлээ сонгоход нь чиглүүлэх;
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааны үр дүнг ажил олгогчид болон шинээр элсэгчдэд сайтар сурталчлан таниулах дээр анхаарах;

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн хэмжээнд оюутны тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг, боловсролын зээлийн үйлчилгээ, оюутан солилцоо, гадаад оюутныг дэмжих үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад үзүүлэх үйлчилгээ, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ, соёл спортын үйлчилгээ, эрүүл мэндийн зөвлөх үйлчилгээ, судалгаа болон санаачилгыг дэмжих үйлчилгээ, дотуур байр, орон сууцны үйлчилгээ, оюутны нийгэмд хандсан үйлчилгээ, цахим үйлчилгээ болон хамтын үйл ажиллагаа гэсэн зөвлөн туслах үйлчилгээнүүдийг хэрэгжүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн багш нарын суралцагчдын бие хүний төлөвшил, эрдэм шинжилгээ судалгааны ажилд зөвлөн туслах үйлчилгээний чанарыг хадгалах;
- Хөдөлмөрийн зах зээл дээр суралцагчдын мэргэжлийн ур чадвараар тэргүүлэх байр сууриа хадгалах;

Анхаарах асуудал:

• Хөтөлбөрөөр суралцагчдад одоо суралцаж буй бакалаврын оюутны болон амжилттай ажиллаж буй төгсөгчдийн туршлагын талаар хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулж байх;

Зөвлөмж:

• Хөтөлбөрөөр суралцагчдад Биохими хөтөлбөрийн төгсөгчдийн амжилт ба ажил олгогчдын санал, зөвлөн туслах үйлчилгээнүүдийг тогтмол зохион байгуулж байх.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн хэмжээнд Оюутан, төгсөгчийн хэлтэс зохион байгуулан олон төрлийн клубүүд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус хэлтэс нь хичээлийн жилийн улирал бүрийн эцэст оюутны клубүүдээс тухайн улиралд зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг хүлээн авч, идэвхтэй ажиллаж байгаа клубүүдийг шалгаруулан дараагийн улиралд үйл ажиллагаагаа явуулах өрөө тасалгаа, шаардлагатай үед боловсруулсан удирдамжид нь үндэслэн төсвөөр хангах зэргээр дэмжин ажилладаг.
- "Probe" Биотехнологийн клуб нь 2010 оны 4-р сарын 1-ний өдөр Биотехнологийн чиглэлээр суралцдаг оюутан залуусын санаачилгаар үүсгэн байгуулагдсан ба тасралтгүй 11 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Оюутнуудын эрдэм мэдлэг, хичээл сурлага, эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагаанууд болох Оюутны эрдэм шинжилгээний бага хурал, "Биотехнологи-Бидний ирээдүй" биотехнологийн олимпиад, "Бид ирээдүйн Нобелийн шагналтнууд" шинжлэх ухааны өдөрлөг зэрэг үйл ажиллагаануудыг тогтмол зохион байгуулж ирсэн. Шинжлэх ухаанд сонирхолтой оюутнуудаас жилд нэг удаа нээлттэй гишүүн элсүүлж, нийт гишүүдийн хурлаар тухайн жилийн клубийн бүтэц, бүрэлдэхүүнээ сонгодог (<https://www.facebook.com/ProbeClub>).

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багш нарын суралцагчдын бие хүний төлөвшил, эрдэм шинжилгээ судалгааны ажилд зөвлөн туслах үйлчилгээ тогтворжсон, үр дүн сайтай.
- Хөдөлмөрийн зах зээл дээр төгсөн гарсан төгсөгчдийн мэргэжлийн ур чадвараас илүү багаар ажиллах чадвар сайн байна. /ажил олгогчдын уулзалт дээр тодорхой жишээнүүдээр хэлж байсан/
- Биохими хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууд МУИС-ийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг клуб, сайн дурын байгууллагуудад хамрагддаг эсэхийг тандан судлахад оюутнуудын 38% нь "тийм" буюу тогтмол оролцдог, 62% нь клубт ямар нэг харьяалалгүй, гэхдээ зохион байгуулж буй үйл ажиллагаануудад оролцож байсан.
- 2016-2020 онд Биохими хөтөлбөрийг төгссөн нийт 21 төгсөгчөөс ажил байдлын судалгаа авахад 90% нь бакалаврын дипломын ажил бичиж төгссөн ба тэдний 28.5% нь ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд, 19.5% нь хувийн хэвшлийн үйлдвэр, лабораториуд, 31% нь гадаад дотоодын их сургуулиудад ахисан түвшинд суралцаж, гадаад дотоодын их сургуулийн ахисан түвшинд суралцаж буй оюутнууд мэргэжлээрээ давхар ажилладаг байна. Харин нийт төгсөгчдийн 22% нь улсын болон хувийн дунд сургуульд багш эсвэл өөр салбарт ажиллаж байна. Энэ нь тус хөтөлбөрийг төгссөн оюутнуудын 70% гаруй хувь нь төгсөөд мэргэжлээрээ ажиллаж, ахисан түвшинд суралцдаг, нийгэмд эрэлттэй хөтөлбөр болохыг харуулж байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн клубийн үйл ажиллагаагаар дамжуулан хөтөлбөрийн багш, оюутнууд нийгэмд мэдлэг түгээх, байгалийн ухаанд сонирхолтой сурагч, оюутны менторшип

хөтөлбөр зохион байгуулах зэргээр шилдэг сурагчдыг татан хөтөлбөртөө элсүүлэх дээр анхаарах;

- Биохими хөтөлбөрөөр суралцагчдын хамтран байгуулсан гарааны компани байгуулах төслийн үйл ажиллагаа үр дүнг оюутнуудад сурталчлах, дараагийн шинэ төсөл бий болгох сэдлийг байнга төрүүлж байх;

Зөвлөмж:

- МУИС-д хэрэгжүүлж буй суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжих клубүүдийн үйл ажиллагаанаас гадна тэнхимийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг клубүүд, сайн дурын байгууллагуудын үйл ажиллагааг улам өргөжүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн захирлын 2019 оны 11-р сарын 14-ний өдрийн А/483 тоот тушаалаар “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам” шинэчлэгдэн батлагдсан.
- Шилжилт хөдөлгөөнийг хичээлийн жилд 2 удаа зохион байгуулах бөгөөд шилжилтийн бүртгэлийг намрын улиралд 7 сарын 01-ээс 8 сарын 15, 92 хаврын улиралд 12-р сарын 15-аас 01-р сарын 15-ыг дуустал <https://burtgel.num.edu.mn> бүртгэлийн нэгдсэн системээр бүртгэнэ. Шилжин суралцагч нь хүссэн хөтөлбөрийн дагуу шалгалт өгөх бөгөөд шалгалтад авбал зохих онооны 60-аас доошгүй хувийг авсан шилжин суралцагчдыг оноогоор нь жагсааж хяналтын тоонд багтаан элсүүлнэ.
- МУИС-ийн захирлын 2019 оны 11-р сарын 18-ны өдрийн А/495 тоот тушаалаар “МУИС-д хичээл дүйцүүлэх журам” батлагдсан. Энэхүү журамд хичээл дүйцүүлэхэд баримтлах зарчим, багц цаг шилжүүлэн тооцох аргачлал, суралцагчийн үнэлгээ /дүн/-г тооцох аргачлал, гадаад хэлний шалгалтын оноог дүйцүүлэх, хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа зэргийг нарийвчлан тусгасан байдаг. МУИС-ийн хичээл дүйцүүлэлтийн үйл ажиллагааг Дүн, бүртгэл хариуцсан нэгж/мэргэжилтэн нь суралцагч, мэргэжлийн тэнхимтэй хамтран зохион байгуулна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн 5 жилд 5 суралцагч Биохими хөтөлбөрт шилжин суралцсан байна.
- МУИС-ийн сургалтын алба суралцагчдын шилжилт, хөдөлгөөн, гарч болох эрсдэлийг бууруулах, суралцагчдад хүндрэл учруулахгүй байх зорилгын хүрээнд шаардлагатай журмуудыг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2019 оны А/495 тоот тушаалаар “МУИС-д хичээл дүйцүүлэх журам” батлагдсан.

Анхаарах асуудал:

- МУИС-аас өөр байгууллагын судалгааны лабораторид ажиллаж мэргэжлээ дээшлүүлэх үүднээс ажиллаж буй суралцагчдад багц цагийн хөнгөлөлт, эсвэл дүйцүүлэх боломжтой эсэхэд анхаарах

Зөвлөмж: 2019 оны А/495 тоот тушаалаар “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”-ын хэрэгжилтэд хичээлийн агуулгын давхцалыг мэргэжлийн багш нараар хянуулж байх.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн захирлын 2015 оны 06 сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан Сургалтын журмын 4.112.4-т заасны дагуу МУИС-ийн захирлын тушаалаар төгссөн мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, дипломын хавсралт, энгэрийн тэмдэг олгоно. Бакалаврын зэргийн диплом нь МУИС-ийн Удирдах зөвлөлийн дарга, МУИС-ийн захирал, төгсөлтийн ерөнхий комиссын дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирлын гарын үсэг, МУИС-ийн тамга тэмдгээр баталгаажих ба дугаар, бүртгэлийн дугаартай байдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Биохими хөтөлбөрөөр төгсөгчдийн тоо сүүлийн 5 жил буураагүй тогтмол байгаа нь энэ хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар, төгсөгчдийн ажил эрхлэлт, ажил олгогчдын сэтгэл ханамжтай холбоотой.
- Эдгээрийн хэрэгцээ шаардлага төгсөлтийн баримт бичигт бүрэн туссан байна.

Анхаарах асуудал:

- Журмын дагуу явагддаг тул анхаарах зүйл байхгүй байна.

Зөвлөмж:

- Биохими хөтөлбөрөөр төгсөж буй дипломын ажил бичээгүй оюутнуудаас улсын шалгалт авах, эсвэл бүгд диплом бичдэг болгох асуудал шийдэгдвэл төгсөлтийн баримт бичигт оруулах.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн сонгон шалгаруулалтыг МУИС-ийн хүний нөөцийн бодлого болон бусад хууль дүрэмтэй уялдуулан олон нийтэд нээлттэй зарлан, эсвэл шууд сонгон шалгаруулж авдаг (Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага, “МУИС-д профессор, багш ажиллуулах журам”-ын 5 дугаар бүлэг).
- Хөтөлбөрт нь эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш нартай. Багш нарын 75% нь докторын зэрэгтэй, 3 нь проф., 2 нь зөвлөх проф., 9 нь дэд проф., 1 нь ахлах багшийн албан тушаалын зэрэглэл дээр ажиллаж байна;
- 2016 онд 2 багш, 2017 онд 3, 2019 онд 1 багш нийт 6 багш сонгон шалгаруулж авсан.
- Тэнхимийн багш болон проф., дэд проф. цолтой багшийн харьцаа 1:1.3 байна.
- Багшийн зэрэглэлийн болзлыг хангасан багш нар тодорхой хугацаанд ажилласны дараа албан тушаалын зэрэглэл ахих боломжтой.
- Хөтөлбөрийн багш оюутны харьцаа 2018 онд 2.2, 2019 онд 3.2 байсан бол 2020 онд 3.5 болж бага зэрэг өссөн (ӨҮТ, х. 104-105). Хэдийгээр нэг багшид ногдох оюутны тоо бага байгаа боловч энэ нь багш нар оюутантай тулж ажиллах боломжийг олгож байна. Хөтөлбөрийн оюутны тоог голлох багш нарын тоонд харьцуулбал нэг багшид 10 оюутан ноогдож байна.
- Багш нарын цагийн ачааллыг А, Б, В цагийн биелэлтээр тооцдог ба хөтөлбөрийн багш нарын А, Б цагийн гүйцэтгэл хангалттай байна.
- Чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээнд суурилан багшийг урамшуулах тогтолцоо бүрдсэн, урамшууллын бодлого хэрэгждэг (МУИС-ийн шагнал урамшууллын нийтлэг журам).
- Web of Science болон Scopus мэдээллийн санд нэг, хоёрдугаар зохиогч, хамтран зохиогчоор өгүүлэл хэвлүүлсэн багш нарыг шагнаж урамшуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багшлах боловсон хүчний нөөц хангалттай, залгамж халаагаа бэлдсэн.
- Багш, ажилтны сонгон шалгаруулалт ил тод явагддаг, багшийн зэрэглэл нь хийсэн ажлын үр дүнгээр хэмжигдэн зэрэглэл ахих боломжтой, багшийн урамшууллын бодлого тасралтгүй явагддаг.

Анхаарах асуудал:

- Багш оюутны харьцааг олон улсын жишигт хүргэхийн тулд уг хөтөлбөрийг сонгох оюутны тоог нэмэгдүүлэх;

Зөвлөмж:

- Нэг багшид оногдох оюутны тоог нэмэгдүүлэх;

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Биохими хөтөлбөрийн багш нар Багшийн хөгжил цахим сургалтын төвөөс зохион байгуулагддаг жил бүрийн сургалтуудад хамрагдахаас гадна үр дүнд суурилсан боловсролын зарчим, үзэл баримтлалд үндэслэн багшлахуй, суралцахуйг сайжруулахад багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтууд, багш нарын академик хэрэгцээ, шаардлагын хүрээнд тэдний судалгааны арга зүйг сайжруулахад чиглэсэн сургалт, хөтөлбөрүүд зэрэг сургалт хөтөлбөрт тогтмол хамрагддаг.
- МУИС-ийн Багшийн хөгжлийн төв Хөтөлбөрийн багш нар дотоод гадаадын мэргэжил нэгт эрдэмтэдтэй хамтран ажиллаж мэргэжлийн болон эрдэм шинжилгээний ажлын талаар туршлага судалж ажилдаа нэвтрүүлдэг. 2016-2020 онд 5 багш гадаад оронд сургалтад хамрагдсан, 3 багш гадны их сургуулийн лабораторид ажиллаж үр чадвараа хөгжүүлсэн байна.
- Хичээл цахим хэлбэрээр явагдсантай холбоотойгоор багш нар цахим орчинд сургалт явуулах арга зүйд суралцсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөдөө орон нутагт судалгааны ажлаар явахаас гадна ЕБС-ийн болон их дээд сургуулийн багш нарт сургалт зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт хичээл заадаг багш нарыг боловсрол судлал, сурган заах арга зүйн сургалтанд тогтмол хамруулах, заах арга зүйд онцгой анхаарах, давтан сургах;

Зөвлөмж:

- Гадаадын их дээд сургууль, судалгааны хүрээлэнтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх, багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг эрж хайх;

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Судалгааны ажлын хамрах хүрээ, түвшинг дэлхийн жишигт нийцүүлэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд тогтмол судалгаа хийдэг болгохыг зорин ажиллаж байгаа нь дэвшилттэй байв. Сүүлийн үеийн тоног төхөөрөмж бүхий судалгааны багууд ажиллаж байна.
- Сүүлийн 5 жилд тэнхимийн багш нар олон улсын байгууллагатай хамтран 10 төсөл, бусад санхүүжилтээр 19 төсөл тус тус хэрэгжүүлсэн ба төслийн хүрээнд магистр болон бакалавр оюутны судалгааны ажилд тэтгэлэг олгосон. Эдгээр төслийн тайлан, төсвийн зарцуулалтыг тухай бүрд нь тогтмол гүйцэтгэж үр дүнг тайлагнадаг байна.
- Хөтөлбөрийн багш нар 2016-2020 онд давхардсан тоогоор ОУ-ын сэтгүүлд 34, дотоодод 64 өгүүлэл хэвлүүлж ОУ-ын хуралд 40, дотоодод 54 илтгэл хэлэлцүүлсэн байна. Эдгээр бүтээлээс одоогийн байдлаар 492 удаа (Google scholar) эшлэгдээд

байна. Нэгдүгээр зохиогчоор хэвлүүлсэн өгүүллээс 31 удаа эшлэл (IF 5.037) авсан; сэтгүүлийн хамгийн өндөр IF 8.154 байна.

- Хөтөлбөрийн багш нар оюутнуудын хамт 7 патент, 1 ашигтай загварын эрх хамгаалсан.
- Багшийн хөгжлийн төвөөр дамжуулан судалгааны ажилд шаардлагатай сургалт, семинарыг тогтмол явуулан судлаачдын мэдлэг боловсролыг дээшлүүлж байгаа нь сайшаалтай байв (Багшийн цахим хөгжлийн төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багш нар олон улсын болон дотоодын эх үүсвэр бүхий төслүүдийг хэрэгжүүлж, сургалт, судалгааны лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулахаас гадна оюутан, суралцагчдыг судалгааны ажилд татан оруулж, ажлын байранд зуучлах, ахисан түвшинд суралцах боломжуудыг бий болгож байна.

Анхаарах асуудал:

- Судалгаа шинжилгээ хийх, судалгааны үр дүнгээ хэвлэн нийтлүүлэхэд олгодог дэмжлэгт магистр зэрэгтэй багш нарыг хамруулахад анхаарах;

Зөвлөмж:

- Инновацыг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багш өөрийн үнэлгээний тайлангаа бичиж тэнхим, хамт олноор хянуулан тодорхой оноогоор үнэлүүлдэг (SiSi систем).
- Багшийн үнэлгээг холбогдох дүрэм, журмыг баримтлан тогтмол явуулж, дүгнэдэг. Багшийн ажлыг сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээний ажил, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ гэж 3 ангилан үнэлнэ.
- Өөрийн үнэлгээний онооны 20%-ийг оюутны багшид өгөх үнэлгээ эзэлдэг.
- МУИС-ийн хэмжээнд багшийн хөндлөнгийн үнэлгээг SiSi программын тусламжтайгаар тогтмол хийж хэвшсэн. Багшийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний систем нь багшийн албан тушаалын ангиллыг нэмэгдүүлэхэд хэрэглэгдэж байна (МУИС-ийн профессор багш ажиллуулах журам, Багшийн үнэлгээний нэгдсэн журам “Аттестатчиллын”).
- Багшийн хавтсыг “Биохими” хөтөлбөрийн багш нар жигдрүүлэн бэлтгэсэн ба үүнд: төрийн албан хаагчийн анкет, боловсролын зэргийн дипломын хуулбар, мэргэжил дээшлүүлсэн байдал, шагнал урамшуулал, бүтээлийн жагсаалт, патент, номын зохиогчийн эрх, хичээлийн жилийн ажлын төлөвлөгөө зэрэг багтсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- SiSi мэдээллийн системийн тусламжтайгаар оюутнуудаар багшийг үнэлүүлдэг.

Анхаарах асуудал:

- Багшийн хувь хүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн сургалтууд цөөн явагддаг, энэ чиглэлийн сургалтад хамрагдсан багш нар цөөн.
Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ доогуур байгаа багшийн бүтээмжийг сайжруулахад анхаарах;

Зөвлөмж:

- Багш нарыг хувь хүний хөгжлийг дээшлүүлэх сургалтад хамруулах;
- Судалгаа шинжилгээний материаллаг баазыг бүрдүүлэхэд өгч буй санхүүжилтийг нэмэгдүүлэх

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- 2014 оноос МУИС-д бүтцийн өөрчлөлт явагдан хуучин бүрэлдэхүүн сургууль, тэнхимүүдийг нэгтгэсэн. 2015-2016 оны хичээлийн жилээс МУИС-ийн захирлын 2015 оны 06 сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан “Монгол улсын их сургуулийн Сургалтын журам”-ыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ журмын 2.1-д заасны дагуу МУИС-д Дээд боловсролын зэрэг олгох сургалтын ажлыг сургалтын нэгдсэн алба болон бүрэлдэхүүн, харьяа сургуулийн сургалтын алба зохион байгуулна гэж заасны дагуу сургалтын бүхий л үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалт, удирдлагад шилжүүлэн ажиллаж эхэлсэн.
- БШУЯ-ны Азийн Хөгжлийн банкны санхүүжилттэй Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд МУИС нь “Дээд боловсролын сургалтын байгууллагын хөгжлийг дэмжих” тэтгэлэгт төслийн хүрээнд Сургалтын чанарын удирдлага, менежмент төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд Европын холбооны дээд боловсролын стандарт, ХБНГУ-ын дээд боловсролын зэрэг олгох хөтөлбөрийг магадлан итгэмжлэх 127 байгууллага болох ASIIN-ны хөтөлбөрт тавих шаардлага, шалгуур үзүүлэлт, стандартыг орчуулж БМИҮЗ-ийн шалгуур үзүүлэлттэй харьцуулан, МУИС-ийн чанарын менежментийн тогтолцоонд үнэлгээ хийсэн ба МУИС-ийн 2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөнд үндэслэн МУИС-д чанарын удирдлагыг хэрэгжүүлэх, МУИС-ийн бүтцэд Чанарын баталгаажуулалтын албыг байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, албаны үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх үүрэг, тус албаны бүтэц, зохион байгуулалт, албаны дарга, мэргэжилтнүүдийн ажлын чиг үүргийг боловсруулсан.

- МУИС-ийн захирлын 2017 оны 10 сарын 13-ны Б/500 тушаалаар Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба гэсэн нэгж (бүтэц)-ийг үүсгэн ажилласан ба 2018 оноос уг нэгж нь Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс (ХЧБХ) нэртэйгээр 10 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.
- Сургалтын журам, Бакалаврын өдрийн хөтөлбөрт 2020 онд оюутан элсүүлэх журам, Бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журам, Суралцагч шилжүүлэн суралцуулах журмыг баталж мөрдөн ажиллаж байна.
- 2015-2016 оны хичээлийн жилээс МУИС-ийн захирлын 2015 оны 06 сарын 30-ны өдрийн А/203 тоот тушаалаар батлагдсан “Монгол улсын их сургуулийн Сургалтын журам”-ыг хэрэгжүүлж эхэлсэн ба уг журмын дагуу сургалтын хөтөлбөр боловсруулах, батлах, өөрчлөх үйл явцыг МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журмаар зохицуулна гэж заасан. Үүнтэй холбоотой МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журмыг батлан ажилласан.
- Хөтөлбөрийн хороо нь Хөтөлбөрийн Ерөнхий хороо (ХЕХ), Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороо (ЕСХХ), Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо (БСХХ), Тэнхимийн хөтөлбөрийн хороо (ТХХ), Салбар дундын хөтөлбөрийн хороо (СДХХ) гэсэн бүтэцтэйгээр ажилладаг.
- Хөтөлбөрийн хороодын бүрэлдэхүүний дийлэнх нь МУИС-ийн багш нараас бүрдэх бөгөөд энэ нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, сайжруулах, үнэлэх, дүгнэх үйл ажиллагаанд багш нар бүрэн оролцдогийг харуулж байна.
- Ерөнхий суурь хичээлийн асуудлыг ЕСХХ-оос үнэлгээ хийж ХЕХ-нд санал оруулна. МУИС-ийн хөтөлбөрийн хороо нь Эрдмийн зөвлөл, МУИС-ийн үндсэн багш, сургалт эрхэлсэн захиргааны ажилтан, ажил олгогчид, төгсөгчдийн төлөөлөлтэй (заалт 4.1). Хөтөлбөрийн хорооны гишүүн нь 4 жилээс дээшгүй хугацаагаар ажиллах бөгөөд 2 жилд 1 удаа хорооны бүрэлдэхүүний 1/3-ийг шинэчилж болно (заалт 4.7). Хөтөлбөрийн ерөнхий хороо 21, Ерөнхий суурийн хөтөлбөрийн хороо 11, Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо 7-11 (ШУС-ийн хувьд 13), Тэнхимийн хөтөлбөрийн хороо 5-7, Салбар дундын хөтөлбөрийн хороо 7 хүртэл гишүүнтэй байж болно

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг боловсруулах, батлах, өөрчлөхөд баримтлах дүрэм журам, эрх зүйн баримт бичгүүд боловсрогдон батлагдсан.
- Бүх шатны хөтөлбөрийн хорооны тогтолцоо, хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоо бүрэлдсэн.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шат, хэрэгжилтийн тогтолцоонд үнэлгээ тогтмол хийж, сайжруулах арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлдэг.
- Хөтөлбөрийн удирдлага нь хөтөлбөрийн хороог ахлан ажиллах тул асуудлаа ойлгох, шийдвэрлэхэд хялбар.
- Монгол Улсад Биохими мэргэжлээр бэлдэж байгаа цорын ганц хөтөлбөр.
- Төгсөгчдийн ажил эрхлэлт, үүнээс мэргэжлээрээ ажиллах төгсөгчдийн эзлэх хувь өндөр.

- Хөтөлбөрийн олгож буй мэргэжлийн мэдлэг, чадвар ажил олгогчид, төгсөгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцэхээс гадна төгсөгчид ажил олгогчийн шаардлагыг бүрэн хангасан, бие даан болон багаар ажиллах, манлайлан зохион байгуулах, санаачилгатай ажиллах, амаар болон бичгээр тайлагнах ур чадвар өндөртэй.
- Төгсөгчид ажлын байранд хөрвөн ажиллах, мэргэжлээрээ өсөж, цаашид суралцах боломжоор хангагдсан.
- Биохими мэргэжлээр суралцан төгсөгчид мэргэжлийн болон хувь хүний чадамжуудыг бүрэн хэмжээнд эзэмшсэн, улс орны хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай тогтвортой ажиллаж, амьдрах цогц чадамжтай.

Анхаарах асуудал:

- МУИС-ийн зүгээс төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг тогтмол гаргах, хэтийн төлөвийг тодорхойлох, суралцагч болон олон нийтэд мэдээлэх нь хангалтгүй
- Төгсөгчдөд бизнес эрхлэх ур чадвар эзэмшүүлэх тал дээр анхаарах;
- Компьютер, интернэт ашиглах ур чадвар эзэмшүүлэх тал дээр анхаарах;
- Туршлагад суурилсан сургалт дутагдалтай

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын ажлыг тасралтгүй явуулах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн зүгээс төгсөгчдөөс ажил эрхлэлтийн судалгааг тогтмол зохион байгуулдаг бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд гэхэд 2017 онд төгссөн бакалаврын түвшний 2619 төгсөгчдийн ажил эрхлэлт, мэргэжил, ур чадварын хөгжил болон хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг судалж, дүн шинжилгээ хийх зорилгоор түүврийн аргаар 1021 төгсөгч буюу төгсөгчдийн 39 хувьд ажлын байрны мөшгөх судалгаа явуулсан (Диаграмм 7.2.1.).
- МУИС-ийн хувьд гаргасан дүнгээр судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 73 хувь нь ажил эрхэлж байсан бөгөөд үүний 46.4 хувь нь хувийн хэвшлийн, 18 хувь нь төрийн байгууллагад, үлдсэн 8.6 хувь нь бусад салбарт ажиллаж, ажил эрхлээгүй төгсөгчид 17 хувийг эзэлж, үргэлжлүүлэн суралцаж байгаа төгсөгчид 10 хувийг эзэлсэн байна. ШУС-ийг БУС-ын Биохимийн хөтөлбөрийн хувьд төгсөгчдийн судалгааг тогтмол явуулдаг бөгөөд хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотойгоор 2021 оны 02 сарын 23-аас 2021 оны 03 сарын 04-ний хооронд 2016-2020 онд Биохими хөтөлбөрөөр төгссөн 21 төгсөгчийг хамруулах ажил эрхлэлтийн байдал, тухайн ажлын байр, албан тушаал дээр ажиллахдаа авч байгаа цалин хөлс, цаашид албан тушаал ахих боломж, хөтөлбөрөөр төгсөгчийн олж авсан ур чадвар, хувь хүн, мэргэжлийн компетенци, хөтөлбөрийн давуу болон сул тал зэргийг багтаасан санал асуулга авч ажилласан (асуулгыг Хавсралт 7.2.1-д бүрэн эхээр оруулсан). Судалгааг

богино хугацаанд амжилттай гүйцэтгэхийн тулд санал асуулгын online platform болох Microsoft TEAMS ашиглан явуулсан.

- Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 95 хувь нь Биохимийн хөтөлбөрөөр төгссөнөөс хойш ямар нэгэн ажил эрхэлж байгаа, 5 хувь буюу 1 төгсөгч гадаадад сурч байгаа учраас ямар нэгэн ажил эрхлээгүй байна гэж хариулжээ. Энэ нь МУИС-ийн хувьд өндөр үзүүлэлт болж байна.
- Төгсөгчдийн ажил хайх идэвх төгссөнөөс хойш эхний 1-ээс 3 сарын хооронд өндөр, төгссөнөөс хойш 2 хүртэлх сарын хугацаанд ажилд орох магадлал өндөр байна. Төгссөнөөс хойш ажил эрхэлж байгаа төгсөгчдийн 38.1 хувь нь суралцаж байх хугацаандаа эсвэл төгсөөд шууд ажил эрхэлсэн бол 33.3 хувь нь 1-2 сарын дараа ажил эрхэлсэн, ажил эрхэлж байгаа төгсөгчдийн 66.7 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна. Мэргэжлээрээ ажиллангаа давхар суралцаж байгаа төгсөгчид 23.8 хувийг эзэлж байгаа нь төгсөгчид мэргэжлээрээ ажиллангаа магистр, докторын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэл сонирхолтой болохыг харуулна.
- Төгсөгчдийн нэг сарын цалин дунджаар 750.000-1.000.000 төгрөг байгаа нь судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 48 хувийг эзэлсэн.
- Төгсөгчид МУИС-ийн, БУС-ын Биологийн тэнхимийн Биохимийн хөтөлбөрийн давуу тал гэдэгт судалгааны чадавх, багш нарын мэдлэг ур чадвар, сургалтын төлбөр, бусад мэргэжил хөтөлбөрөөс суралцах боломж, анги танхим, тоног төхөөрөмжийн хүртээмжийг (95.2-оос 61.9 хувь) давуу талууд гэж хариулсан байна.
- Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэн, Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэн, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар-ХАБҮЛЛ, СҮҮ ХХК, Томүжин алтернатив сургуулийн төлөөлөл байсан бөгөөд ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг төгсөгчийн мэдлэг, чадвар, ажил олгогчийн чухалчилдаг чадварууд юу байдаг, манай төгсөгчид ажил олгогчийн шаардлагад хир нийцэж байгаа, төгсөгчийн давуу болон сул тал зэргийг багтаасан санал асуулга авч ажилласан (асуулгыг Хавсралт 7.2.2.-т бүрэн эхээр оруулсан). Судалгааг online platform болох Microsoft TEAMS ашиглан явуулсан.
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс харахад Биохимийн хөтөлбөрөөс оюутнууддаа олгож буй мэргэжлийн мэдлэгийг 72 хувь нь өөрсдийн ажлын шаардлагад нийцдэг гэж үнэлжээ.
- Нийт ажил олгогчдын 85.7 хувь нь асуудлыг шийдэх, санаачилгатай байх, цаг төлөвлөх, цаг баримтлах, багаар ажиллаж чадварыг чухалчилдаг гэж хариулсан байна. Энэ үр дүнг бид цаашид хөтөлбөрийг сайжруулахад ашиглан ажиллана.
- Биохими хөтөлбөрийн төгсөгчдийн санал асуулгын дүнгээр 95% нь ажлын байраар хангагдсан ба түүний 71% нь одоогийн хашиж буй албан тушаалдаа сэтгэл хангалуун байхаас гадна төгсөгчдийн 57 хувьд нь албан тушаал ахих боломж гарч байсан гэжээ. Ингэхдээ төгсөгчдийн 38.1 хувьд нь ажилд орсноос хойш 1-3 жил, 9.5 хувьд нь 4-8 жилийн дотор албан тушаал/зэрэглэл ахих боломж гарч байжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн зүгээс төгсөгчдөөс ажил эрхлэлтийн судалгааг тогтмол зохион байгуулдаг бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд гэхэд 2017 онд төгссөн бакалаврын түвшний

2619 төгсөгчдийн ажил эрхлэлт, мэргэжил, ур чадварын хөгжил болон хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлыг судалж, дүн шинжилгээ хийх зорилгоор түүврийн аргаар 1021 төгсөгч буюу төгсөгчдийн 39 хувьд ажлын байрны мөшгөх судалгаа явуулсан.

- ШУС-ийг БУС-ын Биохимийн хөтөлбөрийн хувьд төгсөгчдийн судалгааг тогтмол явуулдаг бөгөөд хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотойгоор 2021 оны 02 сарын 23-аас 2021 оны 03 сарын 04-ний хооронд 2016-2020 онд Биохими хөтөлбөрөөр төгссөн 21 төгсөгчийг хамруулах ажил эрхлэлтийн байдал, тухайн ажлын байр, албан тушаал дээр ажиллахдаа авч байгаа цалин хөлс, цаашид албан тушаал ахих боломж, хөтөлбөрөөр төгсөгчийн олж авсан ур чадвар, хувь хүн, мэргэжлийн компетенци, хөтөлбөрийн давуу болон сул тал зэргийг багтаасан санал асуулга авч ажилласан.
- Мэргэжлээрээ ажиллангаа давхар суралцаж байгаа төгсөгчид 23.8 хувийг эзэлж байгаа нь төгсөгчид мэргэжлээрээ ажиллангаа магистр, докторын хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах хүсэл сонирхолтой болохыг харуулна.
- Багш нарын зүгээс оюутнуудын сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор сургалтын заах арга зүйгээ сайжруулах, холбогдох сургалтуудад хамрагдах, өөрийн зааж буй хичээлийн агуулгыг сайжруулах, шинэчлэх, шинэ арга зүй турших, нэвтрүүлэх зэргээр ажиллаж ирсэн. Тухайлбал, тухайн хөтөлбөрт ажилласан багш нарын 45-56% жил бүр холбогдох сургалтуудад хамрагдан заах арга, мэргэжил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлж ирснээс гадна багш нарын 61.9% өөрийн заадаг хичээлийн агуулгыг сайжруулах, семинар, лабораторийн хичээлүүдэд шинэчлэлт хийж ажиллаж ирсэн (Шалгуур 6.2-оос дэлгэрэнгүйг харар).
- Энэ нь хөтөлбөрийн хэрэгжилтэд эргэх холбоо үүсгэх, сургалтын чанарыг сайжруулахад эергээр нөлөөлсөн. Тухайлбал, багшийн заах арга, сургалтын арга зүйгээ сайжруулах сургалтуудад хамрагдсан 7 багшийн оюутны санал асуулгаар авсан саналыг улирлаар харьцуулан үзвэл 1.3-8.7 хувиар буюу дунджаар байна 3.7 хувиар нэмэгджээ

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаагаа тасралтгүй явуулах;
- Төгсөгчдийг мэргэжлээр нь төгсөлтийн дараах сургалтад чиглүүлэх /багшлах эрх, мэргэшүүлсэн сургалтууд/ ;
- Төгсөгчдийн Холбоо, мэргэжлийн нийгэмлэг зэрэг төрийн бус байгууллагуудыг зөв зохион байгуулж, төгсөгч сургуулийн хооронд гүүр болж ажиллахад анхаарах;

Зөвлөмж:

- Мэргэжлийн багш нарын зүгээс төгсөгчид болон ажил олгогчдод мэргэшүүлэх сургалтыг олгох;

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх МУИС-ийн захиргааны бүтцэд хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хариуцсан Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс байгуулагдсан нь хөтөлбөрийг нэгдсэн зохион байгуулалт, стандартаар батлах, хөтөлбөрийн хөндлөнгийн үнэлгээг хийх, хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэлт өгөх, холбогдох дүрэм, журмыг боловсруулах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалт, уялдаа холбоотой явуулах боломж бүрдүүлсэн.
- ХЧБХ нь МУИС-ийн стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын бүх хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэх зорилтын хүрээнд бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх мастер төлөвлөгөөг 2018 онд батлуулан хэрэгжүүлж байгаа.
- МУИС нь өөрийн санаачилгаар эрх бүхий, мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэхээр төлөвлөн Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл (БМИҮЗ)-тэй Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны гэрээг байгуулж “Өөрийн үнэлгээний тайлан” бичиж хянуулснаар БМИҮЗ-ийн удирдах зөвлөлийн 2018 оны 06 сарын 26-ны өдрийн 29 тоот тогтоолоор 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдэн Дугаар 20181002 бүхий гэрчилгээ гардан авсан.
- МУИС-ийг 2024 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд тус сургуульд хэрэгжүүлж буй бүх хөтөлбөрийг үндэсний хэмжээнд, шинжлэх ухаан инженерчлэлийн хөтөлбөрүүдийн 50 хувийг олон улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлэх зорилтыг тавьсан. Үүнийг хэрэгжүүлэхээр магадлан итгэмжлэлийн мастер төлөвлөгөө гарган шат дараатай хэрэгжүүлж эхэлсний хүрээнд Биохими хөтөлбөрийн “Өөрийн үнэлгээний тайлан” бичих ажлын хэсгийг МУИС-ийн захирлын 2021 оны 01 сарын 25-ны өдрийн Б/06 тоот тушаалаар байгуулагдан ажилласан ба энэ хугацаанд хөтөлбөрийн багш нарын зүгээс хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ, харьцуулалт хийж, хөтөлбөрийн хөгжлийн цаашдын стратегийг тодорхойлон ажиллажээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хэлтэс нь МУИС-ийн стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан сургалтын бүх хөтөлбөрийг үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэх зорилтын хүрээнд бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх мастер төлөвлөгөөг 2018 онд батлуулан хэрэгжүүлж байгаа (Хавсралт 7.3.3.).
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрсөнийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Анхаарах асуудал:

- Ажил олгогчдын санал, зах зээлийн эрэлт хэрэгцээ, төгсөгчдийн гадаадад суралцах, ажиллах боломж гарцыг эрж хайх, хэрэгжүүлэхэд нь анхаарах, тухайлбал бакалаврын зарим боломжтой хичээлүүдийг англи хэл дээр судлах боломжийг бий болгох;

Зөвлөмж:

- Гадаад оюутан сургах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Гадаадын ижил мэргэжлийн их дээд сургуулиудтай бакалаврын оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

ДҮГНЭЛТ

МУИС-ийн ШУС-ийн биологийн тэнхимээс хэрэгжүүлж буй “Биохими” нэртэй сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд өгсөн өөрийн үнэлгээний тайлан, баримт нотолгоотой танилцаж, оролцогч талуудтай уулзалтууд хийснээр дараах дүгнэлт хийлээ. Үүнд:

- МУИС-ийн зүгээс энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар бодлого, стратеги төлөвлөлт, гадаад, дотоодын их сургуулийн ижил төстэй хөтөлбөрийн харьцуулсан судалгаанд үндэслэн хөтөлбөрийн материаллаг баазыг бэхжүүлэх, сургалтын орчин бүрдүүлэх, мэдээллийн цахим сан ажиллуулах зэргээр анхаарч ажиллаж байна.
- МУИС-д 1966 оноос биохимич мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн бөгөөд анхны 9 биохимичийг 1968 онд төгсгөжээ. Энэ хугацаанд 55 төгсөлтөөр 395 гаруй биохимичид суралцан төгсөж эх орныхоо өнцөг булан бүрд боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага, улсын болон хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн байгууллага, судалгаа, шинжилгээний лабораториудад үр бүтээлтэй ажиллаж байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хөтөлбөрийн баг нь 7 багш, 2 хичээлийн туслах ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
- Өөрийн үнэлгээний тайлангаас харахад МУИС нь боловсролын магадлан итгэмжлэлд хөтөлбөрүүдээ оруулж баталгаажуулах талаар нарийвчилсан төлөвлөгөөтэй ажиллаж, туршлага хуримтлуулан оролцогч болон сонирхогч талуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч тус хөтөлбөрийг удаа дараа шинэчлэн хэрэгжүүлж байна.
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн агуулгын хувьд дээд боловсролын байгууллагын баримт бичигт тавих нийтлэг шаардлагын дагуу боловсруулсан боловч шинэлэг агуулга, арга зүй, үнэлгээний нэгдмэл холбоо, суралцагчдын сурах үйл явцыг дэмжсэн байдал тодорхой харагдахгүй байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нар биохимийн сургалтын арга зүйгээ тогтмол сайжруулж явуулдгийн зэрэгцээ судалгааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, сургалтын болон судалгааны лабораториудаа орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр хангаж, бүтээлч шинэлэг санааг хэрэглэн сургалтаа эрхэлж буй нь харагдаж байна.

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн багш нар мэргэжлийн ур чадвар, чадавх сайтай, сургалтыг олон улсын жишигт хүргэх талаар санаачилга гарган, хөтөлбөрийн агуулга, үр дүнг боловсронгуй болгосоор иржээ. Энэ нь цаашид улам хөгжиж, хөтөлбөрөө олон улсын түвшинд улам сайжруулах боломжтой гэж үзлээ.

МУИС-ийн Биохими бакалаврын хөтөлбөрийн баримт материал, төлөвлөгөө, өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримт, цахим уулзалт ярилцлагад үндэслэн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагад нийцэж байгаа тул шалгууруудыг **Бүрэн хангасан** гэж үзлээ.

| Шалгуур | Бүрэн хангасан (2) | Хэсэгчлэн хангасан (1) | Хангааг үй (0) | Үндэслэл, шалтгаан |
|--|--|------------------------|----------------|--------------------|
| 1 Хөтөлбөрийн төлөвлөлт | + | | | |
| 2 Сургалтын үйл ажиллагаа | + | | | |
| 3 Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл | + | | | |
| 4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт | + | | | |
| 5 Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа | + | | | |
| 6 Багшийн үйл ажиллагаа | + | | | |
| 7 Чанарын үнэлгээ, баталгаажилт | + | | | |
| Дүгнэлт | Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй | | | |

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлагад үндэслэн шинжээчийн баг МУИС-ийн “Биохими” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.


Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн БОЛОВСРОЛ-ын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн баг:

Шинжээчийн багийн ахлагч: А.Гүрбадам

Шинжээчийн багийн гишүүн: Н.Эрдэнэчимэг

Шинжээчийн багийн гишүүн: З.Бурмаа



НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

| | |
|--|--|
| Сургуулийн нэр | Монгол Улсын их сургууль |
| Хөтөлбөрийн нэр | Биохими |
| Хөтөлбөрийн индекс | D 051201 |
| ЗӨВЛӨМЖ | |
| Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт | <ul style="list-style-type: none">- Сургалтын төлөвлөгөөн шинэчлэлийг хийж, лекцийг бага, дадлага, семинар, лабораторийн цагийг ахиу оруулах;- Гадаадын ижил мэргэжлийн их дээд сургуулиудтай бакалаврын оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;- Хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч болон сонирхогч, ажил олгогч талуудыг хамруулан тэдгээрийн хэрэгцээ, сонирхлыг судлан, саналын үндсэн дээр тухайн салбарт мэргэшсэн /анагаах, мал эмнэлэг, ХАА, ШУА-ийн хүрээлэнгүүд/ биохимичдийг бэлтгэх; |
| Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа | <ul style="list-style-type: none">- Биохими хөтөлбөрөөр төгсөж буй дипломын ажил бичээгүй оюутнуудаас улсын шалгалт авах, эсвэл бүгд диплом бичдэг болгох;- Биохими хөтөлбөрөөр төгсөгчдөд хичээл зааж буй мэргэжлийн залуу боловсон хүчнийг боловсрол судлал, сурган заах арга зүйн сургалтанд тогтмол хамруулж, давтан сургах; |
| Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц | <ul style="list-style-type: none">- Суралцагчдын үдийн цай уух, чөлөөт цагаараа ярилцах орчныг бий болгох;- Бодис урвалж хадгалах стандарт шаардлагыг хангасан өрөө, тасалгаатай болох;- Зарим хичээлийн сурах бичгийг сүүлийн үеийн нэмэлт өөрчлөлт оруулж дахин хэвлэсэн сурах бичгээр баяжуулах; |

| | |
|--|--|
| | <ul style="list-style-type: none"> - Шаардлагатай сурах бичгийг эрх авч эх хэлнээ орчуулах; - Дижитал номын сангийн ашиглалтыг сайжруулах; |
| Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт | <ul style="list-style-type: none"> - Оюутнуудын англи хэлний чадварыг сайжруулах арга зам эрэлхийлэх, сургалт зохион байгуулах, хөтөлбөрт тусгах; - Төслийн үр дүнг практикт нэвтрүүлэх, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах; - Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийг нэмэгдүүлэх; - ЕБС-ийн дунд ангиас эхлэн биохимийн шинжлэх ухааны ач холбогдол, хэрэглээг таниулан сурталчлах; |
| Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ | <ul style="list-style-type: none"> - Биохими хөтөлбөрөөр элсэгчдийн элсэлтийн шалгалтыг биологи, хими, математик, физикийн хичээл болгон өргөн сонголттой болгох; - Биологийн тэнхимийн бусад хөтөлбөрүүдийн талаар суралцагч нарт нээлттэй мэдээлэл өгөх, мэргэжлээ сонгоход нь чиглүүлэх; - Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааны үр дүнг ажил олгогчид болон шинээр элсэгчдэд сайтар сурталчлан таниулах; - Хөтөлбөрөөр суралцагчдад биохими хөтөлбөрийн төгсөгчдийн амжилт ба ажил олгогчдын санал, зөвлөн туслах үйлчилгээнүүдийг тогтмол зохион байгуулж байх; - МУИС-д хэрэгжүүлж буй суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжих клубуудын үйл ажиллагаанаас гадна тэнхимийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг клубууд, сайн дурын байгууллагуудын үйл ажиллагааг улам өргөжүүлэх; |
| Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа | <ul style="list-style-type: none"> - Гадаадын их дээд сургууль, судалгааны хүрээлэнтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх, багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг эрж хайх; - Инновацийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх; |
| Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт | <ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын ажлыг тасралтгүй явуулах; - Мэргэжлийн багш нарын зүгээс төгсөгчид болон ажил олгогчдод мэргэшүүлэх сургалтыг олгох; - Гадаад оюутан сургах бодлого боловсруулж хэрэгжүүлэх; |

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

| № | Нэр | Албан тушаал | Зэрэг цол | Ажилласан жил | Заадаг хичээл |
|----|---|---------------|-----------------------------|---------------|---|
| 1 | Ш. Нармандах (химийн тэнхим) 99290200 | Профессор | Профессор, доктор | | Байгалийн танин мэдэх химийн үндэс (Ерөнхий суурь) |
| 2 | Ж. Баярмаа | Профессор | Дэд профессор, доктор | | Хүнс ба эрүүл хооллолт (Ерөнхий суурь), |
| 3 | Б. Батжаргал | Профессор | Дэд профессор, доктор | | Молекул ба эсийн биологи (Ерөнхий суурь), |
| 4 | Б. Очирхуяг | Профессор | Дэд профессор, доктор | | Биохимийн багажит анализ ба логик, Уургийн биохими, |
| 5 | Д. Лхагвасүрэн | Дэд профессор | Доктор | | Молекул ба эсийн биологи (Ерөнхий суурь), |
| 6 | Т. Сувдмаа | Ахлах багш | Доктор | | Биохими I (лаборатори), Биохимийн дадлага I, |
| 7 | Г. Оюундэлгэр | Ахлах багш | Доктор | | Хүнс ба эрүүл хооллолт (Ерөнхий суурь) |
| 8 | М. Хонгорзул | Багш | Магистр | | Биохими I (лаборатори) |
| 9 | Д. Рэнцэнмядаг (химийн тэнхим) 88021931 | Дэд профессор | Дэд профессор, доктор | | Органик хими |
| 10 | Б. Жаргалсайхан 99171902 | Багш | Магистр | | Амьтны биологи |
| 11 | Д. Нямбаяр 99123114 | Дэд профессор | Дэд профессор, доктор | | Ургамлын биологи |
| 12 | Д. Нарантуяа 99051858 | Багш | Магистр | | Микробиологи – лаборатори |
| 13 | Ө. Энэрэлт 89000773 | Дэд профессор | Доктор | | Биофизик |
| 14 | Ч. Баттулга 99183715 | Ахлах багш | Магистр | | Биостатистик |

II. Оюутны нэрс

| № | Оюутны нэрс | Курс | Сонгосон байдал |
|----|----------------|-------------|--------------------------------|
| 1 | А.Алтантуул | Биохими-IV | Тэтгэлэг авсан |
| 2 | М.Аманда | Биохими-IV | |
| 3 | Б.Болорбуян | Биохими-IV | |
| 4 | Г.Намуунаа | Биохими-IV | Тэтгэлэг авсан |
| 5 | Б.Насантогтох | Биохими-IV | Тэтгэлэг авсан |
| 6 | О.Номин | Биохими-IV | ХШУИС-аас шилжиж ирсэн |
| 7 | Ч.Дэлгэрмаа | Биохими-III | |
| 8 | Б.Жараахай | Биохими-III | Монгол коосэн-аас шилжиж ирсэн |
| 9 | Б.Маргад | Биохими-III | |
| 10 | Б.Номин-Эрдэнэ | Биохими-III | Биохими-IV ийн ангийн дарга |
| 11 | О.Чинбаяр | Биохими-III | |
| 12 | Т.Болормаа | Биохими-II | |
| 13 | Г.Дащцоо | Биохими-II | |
| 14 | Х.Мөнхсүвд | Биохими-I | Дотуур байранд амьдардаг |

III. Ажил олгогчдын нэрс

| № | Овог нэрс | Байгууллага | Албан тушаал |
|----|---------------|--|-----------------------------------|
| 1 | Т.Энх-Оюун | МЭХүрээлэн | Лабораторийн эрхлэгч |
| 2 | Болорцэцэг | Хүнсний аюулгүй байдлын улсын төв лаборатори | Лабораторийн эрхлэгч |
| 3 | Л.Сэр-Од | Коосэн | Тэнхимийн эрхлэгч |
| 4 | М.Баяржаргал | ШУА, ХХТХ | Лабораторийн эрхлэгч |
| 5 | Ононсайхан | Орчлон сургууль | Багш |
| 6 | Ц.Батгэрэл | СҮҮ | Чанарын лабораторийн албаны дарга |
| 7 | Д.Гантулга | ШУА, БХ | Захирал |
| 8 | Ц.Оюунсүрэн | ШУА, БХ | Лабораторийн эрхлэгч |
| 9 | Б.Ичинхорлоо | НЭМҮТ | БТ, инновацын албаны дарга |
| 10 | П.Мөнх-Эрдэнэ | Гаалийн төв лаборатори | Ахлах байцаагч |
| 11 | Г.Адъяа | Этүгэн их сургууль | Тэнхимийн эрхлэгч |
| 12 | Баянмөнх | Монос ЭШХүрээлэн | |
| 13 | Б.Баярмаа | ХААИС | ЭШ, инновацын ажлын албаны дарга |
| 14 | Ч.Буянтогтох | МАОЭШХ | |
| 15 | Нарангэрэл | СИНАПС | Захирал |
| 16 | Өнөрболд | Томужин сургууль | Сургалтын менежер |

IV. Төгсөгчдийн нэрс

| № | Овог нэрс | Төгссөн он | Байгууллага | Албан тушаал |
|----|----------------|------------|--|--------------|
| 1 | О.Батдулам | 2015 | | |
| 2 | Ч.Ариунзаяа | 2015 | | |
| 3 | О.Намуунцэцэг | 2015 | | |
| 4 | Т.Билгүүн | 2016 | Хөвсгөл аймгийн ЕБС-д багш | |
| 5 | Х.Номин | 2016 | АПУ ХХК | |
| 6 | А.Энх-Ариун | 2017 | ШУА, ХХТХ, ЭШДА | |
| 7 | Б.Хүрэлсүх | 2017 | ШУА, БХ, ЭША | |
| 8 | А.Халиунаа | 2018 | | |
| 9 | Г.Мөнгөнцоож | 2018 | Эрчим хүчний хөгжлийн төвд химич | |
| 10 | Ц.Манчир | 2019 | Куото-ийн их сургууль, магистрант | |
| 11 | Н.Мөнхзул | 2019 | ХҮМҮН ЕБС-д багш | |
| 12 | Х.Мөнхгэрэл | 2019 | Монгол коосэн технологийн коллеж, багш | |
| 13 | Г.Оюутгэрэл | 2019 | | |
| 14 | Ч.Гэрэлцэцэг | 2019 | | |
| 15 | Б.Лхагвадулам | 2020 | Life tronik, менежер | |
| 16 | Б.Номин | 2020 | НЭМҮТ, ЭША | |
| 17 | С.Содбилэг | 2020 | Special mining service-д химич | |
| 18 | О.Эрдэнэболор | 2020 | Дундговь аймаг, МХ-д шинжээч | |
| 19 | Д.Марал-Эрдэнэ | 2021 | | |

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

| Магадлан итгэмжлэх эсэх | Магадлан итгэмжлэл олгох хугацаа |
|-------------------------|----------------------------------|
| | |

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

| Магадлан итгэмжлэх эсэх | Магадлан итгэмжлэл олгох хугацаа |
|-------------------------|----------------------------------|
| | |

Зөвлөмж /Recommendations/